



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар A/177

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулж,
газар эзэмшүүлэх хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны A/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын 2006 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №25 дугаар захирамжаар Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтэс /РД:9069704/-т Мөрөн сумын 8 дугаар багт байршилтай албан kontорын зориулалттайгаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээг 400m² гэснийг 1283m² гэж өөрчилж газар эзэмшүүлэх хугацааг 15 жилээр сунган эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №25 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3.Газар эзэмшигч Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтэс /РД:9069704/-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

